



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 05 дугаар сарын 02 өдөр Дугаар 12

Хэрлэн сум

XII ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 12 дугаар хуралдаан 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 11:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд цомхотгосон хэлбэрээр 85,0 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1. Цаг агаар, хуурайшилтын нөхцөл байдлын талаар мэдээлэл танилцуулах,
Ус цаг уур, орчны шинжилгээний төв

2. Бүсийн оношлогоо эмчилгээний төвөөс хээрийн түймэрт өртсөн иргэдэд эмнэлгийн тусламж үзүүлэх шуурхай бүлгийг томилон ажиллуулах талаар хэлэлцэх,

Эрүүл мэндийн газар

3. Чойбалсан суманд гарсан хээрийн түймрийн нөхцөл байдлын талаарх мэдээлэл танилцуулах,

Зүүн бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

4. Гурванзагал, Чойбалсан, Чулуунхороот сумдад ажлын хэсэг томилж ажиллуулах тухай хэлэлцэх,

Зүүн бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа-д:

1.1. Чойбалсан, Чулуунхороот сумын Эрүүл мэндийн төвд эмчлүүлж буй хээрийн түймрийн нөөлөгт өртсөн албан хаагч, иргэдийг Бүсийн оношлогоо эмчилгээний төвд татан авч эмнэлгийн тусламж үйлчилгээг шуурхай зохион байгуулах,

Хоёр. Аймгийн Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга,

Онцгой комиссын гишүүн Б. Алтансүх,

Хүнс, хөдөө ахуйн газрын даргын албан үүргийг

түр орлон гүйцэтгэгч Б. Мөнхбаяр,

/ / М.Бадамсүрэн

/ / х/ч Б.Цогтбаяр

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга,
Онцгой комиссын гишүүн А.Гантулга нарт:

2.1.Чойбалсан, Чулуунхороот, Гурванзагал сумдын нутаг дэвсгэрийн гарсан түймэрт өртсөн малчдад туслах, хохирлыг багасгах 2 ажлын хэсгийг Гурванзагал, Чойбалсан, Чулуунхороот сумдад томилж ажиллуулах,

Зүүн бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга,
Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,
Цагдаагийн хурандаа Т.Ганзориг нарт:

2.2.Чойбалсан, Чулуунхороот сумдад гарсан хээрийн түймрийн гарсан шалтгаан нөхцлийг шуурхай тогтоох, гол гарсан дүгнэлтийг гаргах,

2.3.Баян-Уул, Баяндун, Дашбалбар, Цагаан-Овоо, Сэргэлэн сумдад ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, бэлэн байдлыг хангуулах чиглэлээр газар дээр нь очиж ажиллах,


Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга,
Онцгой комиссын гишүүн А.Гантулга,

2.4.Ус цаг, уур орчны шинжилгээний мэдээгээр аймгийн нийт нутгаар салхины хүч ихтэй, хуурайшилтын нэн аюултай зэрэглэлд хүрсэн тул сумдад хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлын хэсгийг томилж ажиллуулах,

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга,
Онцгой комиссын гишүүн В.Цэнгэлмаа-д:

2.5.Хээрийн түймэрт өртсөн сумдад дэмжлэг үзүүлэх зорилгоор Чойбалсан суманд 10,0 сая, Гурванзагал суманд 3,0 сая, Чулуунхороот суманд 3,0 сая төгрөгийг хуваарилан олгохоор шийдвэрлэснийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж хэлэлцүүлэх,

2.6.Хээрийн түймэр гарсан Гурванзагал, Чойбалсан, Чулуунхороот сумдад томилогдож ажиллах ажлын хэсгүүдийн шатахуунд шаардагдах 5,0 сая төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэхийг тус тус үүрэг болгов.

ДАРГА 
М.БАДАМСҮРЭН
НАРИИН БИЧГИЙН ДАРГА,
ХОШУУЧ 
Б.ЦОГТБАЯР